



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/34


Улаанбаатар хот

Эд хөрөнгийг үнэлэх зөвлөмж,
аргачлал боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авто зам, замын байгууламж дагуух хайс хашлага, гэрэлтүүлгийн шон, гэрлэн дохионы шон, ногоон байгууламж болон бусад нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж гэмтээсэн, авто зам бохирдуулсан буруутай эзэн холбогдогчоор хохирлын нөхөн төлбөрийг төлүүлж, хохирлыг барагдуулах, хэрэг шийдвэрлэх ажиллагааг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаатай холбогдуулан дээрх эд хөрөнгийг үнэлэх зөвлөмж, аргачлал боловсруулж, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Зөвлөмжийн төслийг боловсруулж, 2019 оны 02 дугаар улиралд багтаан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулах, үнэлгээний аргачлалыг эцэслэн боловсруулж, 2019 оны 04 дүгээр улиралд багтаан холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаа/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
1154 дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Ц.Рэгзэдмаа Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд	Г.Ууганбаяр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Р.Даваасүрэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Э.Уянга Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль эрх зүйн хариуцсан мэргэжилтэн Д.Итгэл Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга Б.Цэрэнсодном Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Засвар ашиглалт, хяналтын хэлтсийн дарга Р.Цогтоо Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсийн замын хяналтын ахлах зохицуулагч Д.Сүхбат Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Сүлд-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Авто зам хариуцсан мэргэжилтэн

Ш.Чанцалнурмаа
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хот
чимэглэл, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Н.Пүрэвжав
Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын орлогч
дарга

Б.Баатархүү
Улаанбаатар Зам засвар арчлалтын газар
ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер

Ц.Мөнх-Очир
Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ-ын
Мэдээлийн технологи, техник ашиглалтын
хэлтсийн дарга

М.Бизаагундаа
Монголын хохирол үнэлэгчдийн холбоо ГҮТББ-ын
Гүйцэтгэх захирал /Зөвшилцсөнөөр/

А.Ганхуяг
Монголын гэрэлтүүлгийн холбоо ТББ
/Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга

П.Чойжилжав
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны
Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн